

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

2022.11.25

Алтай хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу хийж гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан орон нутагт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг сайжруулах дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангахад чиглэгдлээ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д байршуулсан 2022 оны хэрэгжилтийг тайлагнах 4 бодлогын 16 зорилтын 18 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл: нийт 18 арга хэмжээний 8 нь 100 хувь, 5 нь 90 хувь, 4 нь 70 хувь, 1 нь 50 хувьтай хэрэгжиж, хэрэгжилтийн дундаж 87.78 хувьтай байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 87.78 хувьтай байна.

2. Засаглалын бодлогын “Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.” гэсэн арга хэмжээний 2022 оны хүрэх түвшин нь Өвөрхангайн Төгрөг, Өмнөговийн Мандал-Овоо, Дорноговийн Мандах, Сүхбаатарын Баруун-Урт гэсэн 4 сумд цогцолбор байгуулахаар төлөвлөгдсөн байгаа тул тус аймагт хамааралгүй гэж үзэж, хяналтаас хасуулах саналтай байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

1. Засаглалын бодлогын “Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.” гэсэн арга хэмжээний 2022 оны хүрэх түвшин нь Өвөрхангайн Төгрөг, Өмнөговийн Мандал-Овоо, Дорноговийн Мандах, Сүхбаатарын Баруун-Урт гэсэн 4 сумд цогцолбор байгуулахаар төлөвлөгдсөн байгаа тул тус аймагт хамааралгүй гэж үзэж, хяналтаас хасуулах саналтай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

